



## БАЯН-УУЛ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2023 – 2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН



Энэ хичээлийн жилд **1050** сурагч, **96** багш, ажилтантайгаар сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа зохион байгууллаа.

**2023 – 2024 оны хичээлийн жилийн сургуулийн зорилго:**

Ээлжит хичээлийн чанар, суралцагчийн бие даан суралцах чадвар, байгууллагын менежментийг сайжруулах.



**ЗОРИЛТ-1.** Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх, **сургалтын цахим систем хөгжүүлэх**, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй, бэлэн байдлыг хангах



Боловсролын удирдлагын мэдээллийн систем [esis.edu.mn](http://esis.edu.mn) -д шаардлагатай мэдээ, мэдээллийг оруулах, шинэчлэх, холбогдох дата өгөгдлийг ашиглах зэргээр үр дүнтэй хэрэглэж байна.



Хөтөлбөрт 3, 4 дүгээр ангийн 8 бүлгийн 217 сурагч хамрагдсан. Үүнээс 175 сурагч нь цахим систем дээр идэвхтэй байгаа нь 81 хувийг идэвхтэй хамруулсан гэсэн дүгнэлтэнд хүрч байна.



Сургалтын удирдлагын Амжилт 3.0 системийг ашиглаж цахим болон зайн сургалт зохион байгуулах бүрэн боломж бүрдээд байна.



Энэ хичээлийн жил Medle цахим сургуульд 10 – 11 дүгээр ангийн 40 сурагч 12 төрлийн сонгонд хамрагдлаа.



Хөтөлбөрт 5-р ангийн **97**, 6-р ангийн **93** нийт 7 бүлгийн **190** сурагч хөтөлбөрт хамрагдаж, цахим платформ дээр ажиллах чадварт суралцаж байна. Багш нар жилд 99 цаг, нийт 693 цагийн хөтөлбөрийг хэрэгжүүлж сайн туршлага хуримтлуулсан.




Анги бүр **EDUTEN** булан ажиллуулж сурагчдаа идэвхжүүлсэн.

Нийт 217 сурагчийн 175 нь идэвхтэй байгаа нь сурагчдынхаа 81 хувийг идэвхтэй хамруулсан гэсэн дүгнэлтэнд хүрч байна.



**Дүгнэлт:** Сурагчдын явц ил тод болохоор бие биенээсээ илүү цомтой болохын тулд сурагчдын дунд өрсөлдөөн бий болсон. Үүнийгээ дагаад сурагчдын бие даан ажиллах чадварт ахиц гарсан. Жишээ нь: Ямар ч утсанд өөрийн нууц үг, кодоо хийгээд ордог болсон, даалгавар гүйцэтгэхдээ алхам бүрээ асуухаа больж бие биедээ тусалдаг болсон. Багш тусламж шаардлагатай хүүхдэд цаг зарцуулах боломж илүү болсон.

Эдүтэн үнэлгээ



Feidea Gedeso fodoedo Yeroenkkei  
VibEsore oa Sorgegoll  
Dorogedo Feime! da hEvea feola






# СУРГАЛТЫН ОРЧИН БҮРДҮҮЛЭЛТ

ДОРНОД АЙМГИЙН  
БАЯН-УУЛ СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРЛЫН ТУШААЛ

Монгол Улсын Боловсролын Ерөнхий хуулийн 33.3.3.1, 33.3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сургуулийн дэргэдэх Pearson хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.  
Ажлын хэсгийн ахлагч: Б.Лхагвадорж / Сургалтын менежер /  
Ментор багш: Н.Оюумаа / Англи хэлний багш /  
Гийшүүдэд: Д.Ганчимэг / Англи хэлний багш /  
Б.Жаргалтуяа / Англи хэлний багш /  
Ч.Оюунцагаг / Эцэгт ахлийн төлөөлөл /  
С.Мөнхцэцэг / Эцэгт ахлийн төлөөлөл /

2. Хөтөлбөрийг чиглэлийн дагуу хэрэгжүүлэхийг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ:  Б.БАТХУЯГ

Pearson хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийн тушаал

Хөтөлбөрт 5-р ангийн **97**, 6-р ангийн **93** нийт 7 бүлгийн **190** сурагч хөтөлбөрт хамрагдаж, цахим платформ дээр ажиллах чадварт нь ахиц гарсан ба жилийн эцсийн үнэлгээгээр: 5-р анги 82.3%, 6-р анги 80.4%-тай дүгнэгдэв.




Сургалтын орчин бүрдүүлэхэд 30ш таблет, дэлгэц проектор 2ш, ширээ сандал 20ш, акустик хавтан зэргээр дэмжлэг үзүүлсэн.



Дорнодод Feitme! да Үгүеа feofoa  
VibEsore oa Sorgegoll  
Feidea Gedeso fodoedo Yeroenkki



## Суралцагч зайн, цахим болон бусад хэлбэрээр боловсрол эзэмшихэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлэх.



АНУ-ын Brigham Young –ын их сургуулийн оюутан Mak Hoi Yee-тай хамтарч англи хэлний онлайн хичээлд 6 дугаар ангийн 25 сурагчийг хамруулан амжилттай хамтарч ажиллав. Англи хэлний багш А.Мөнхтуяа нь энэхүү төсөлд 2 дахь удаагаа шалгарч, орон зайнаас үл хамрааран гадаад оюутантай хамтран ажиллаж байна.

Сургалтад цахим технологи ашиглах боломж бүрдүүлэх зорилгоор эцэг эх, асран хамгаалагчийн дэмжлэгээр **анги, танхим бүр TV –тэй болох** аян өрнүүлж ажилласнаар нийт 32 анги, танхимд сургалтын үйл ажиллагаа явагддагаас 19 нь TV-тэй, 6 нь дэлгэц, проектортой болж, 78% нь цахим сургалт зохион байгуулах боломж бүрдсэн.  
**Үр дүн:** Ээлжит хичээлийн чанар, үр дүн сайжирсан.



БШУЯ-аас хэрэгжүүлсэн "Боловсролын сургалтын байгууллагуудад утасгүй дотоод сүлжээ байршуулах" төслийн хүрээнд 53,516,000 төгрөгийн өртөг бүхий дотоод сүлжээний тоног төхөөрөмжийг суурилуулснаар сургуулий орчинд интернет сүлжээний хэрэглээ илүү өргөн, хүртээмжтэй болж, багш, сурагч, ажилчид сургалтын өдөр тутмын үйл ажиллагаандаа өргөн хэрэглэж байна.



Сурагчдыг агуулгын хоцрогдолгүй суралцуулах зорилгоор урт хугацааны чөлөө авах тохиолдолд **Мэдлээ цахим сургуулийн** хичээлийг судлаж, тэмдэглэл хөтлөх зөвлөгөө чиглэл өгч, ажилласнаар мэдлээгийн хичээлүүдийг тогтмол ашиглах дадал хэвшилтэй болж байна.





**ЗОРИЛТ-2. Хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах, тэдний онцлог, сурах хэв маягт нийцсэн хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх **орчин бүрдүүлэх, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах**, сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах**



Хүүхэд бүр чөлөөт цагаа үр бүтээлтэй өнгөрүүлэх, номтой нөхөрлөх тав тухтай орчинг нэмэгдүүлэв. Үүнийг “Бага ангийн багшийг дэмжих” төслийн уралдаанд оролцсон багш нар санаачлан хийв.



**Сургуулийн номын сан:** Хүүхэд бүрийн хамгийн их ирэх дуртай газар. Нэг ээлжиндээ 25 хүүхэд хүлээн авах хүчин чадалтай ч хүүхдийн хөл хөдөлгөөн тасардаггүй.

**Дотуур байр – Номын булан**



**Хөгжлийн онцлогтой** сурагчдын сурах орчинг бүрдүүлж, **ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТАНХИМ** тохижуулав. БАБД төслийн уралдаанд оролцсон багш нар. **Үр дүн:** Ганцаарчлан ажиллах танхимтай болсон.



**Хүүхэд хөгжлийн танхим дахь ХБХ-ийн сургалтын тохирох хэрэглэгдэхүүн**



# Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж, сурлагын амжилтад ахиц гаргах

- ЕБС-ийн суралцагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх
- БГҮ-ний үр дүнд “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт – 53.08%-тай хангалтгүй үнэлэгдсэн.
- ЭЕШ-ын дундаж оноогоор өмнөх оноос 31.9 оноогоор буурсан зэрэг үзүүлэлтэд үндэслэн, энэ хичээлийн жилд “Сурлагын хоцрогдлыг бууруулах” тэргүүлэх зорилт дэвшүүлж, “Сурлагын хоцрогдол арилгах” сургуулийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн.

БАТЛАВ  
БАН-УУЛ ЕБС-ИЙН ЗАМРАЛ  
СУРЛАГЫН ХОЦРОГДОЛ АРИЛГАХ ХӨТӨЛБӨР  
2023-2024 оны хичээлийн жил

ТҮНДЭСЛЭЛ

- Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дүнгээр “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт” 53.08%-тай үнэлэгдсэн.
- Эсэлтийн өрөөний шалгалтын дундаж онооны үзүүлэлтээр өмнөх оноос 31.9 оноогоор буурсан төдийгүй сүүлийн жилүүдэд хөвгүүд маш хангалтгүй үнэлэгдэх болсон.
- Багш, сурагчид, эцэг эхээс авсан судалгаагаар “Сурагчдын бие даан суралцах болон эмгэг цэгцтэй ерх чадвар”-ыг хөгжүүлэх шаардлагатай байна гэсэн дүгнэлт гарсан нь Ковидын үеийн зайны сургалтын үеийн нийгэмшихийн болон сурлагын хоцрогдол үргэлжилсээр байгааг илтгэж байна.
- 2023-2024 оны хичээлийн жилд “Сурлагын хоцрогдлыг бууруулах” тэргүүлэх зорилт болгон тавьсан.

ЗОРИЛГО

Сургалтын чанарыг сайжруулах, сурлагын амжилтад ахиц гаргах.

ЗОРИЛТ:

- Оноолдох үнэлгээ хийж
- Сурлагын хоцрогдолтой хүүхэд бүрийн онцлог, ялгаатай байдал, хэрэгцээг судлах
- Суралцагчийн хэрэгцээнд тулгуурлан дэмжин хөгжүүлэх үйл ажиллагаа зохион байгуулах

ХУГАЦАА: 2023 - 2024 оны хичээлийн жилээс үе шаттай хэрэгжүүлэх.

ХАМРАХ ХТРЭЭ: Сурлагын хоцрогдолтой гэж оношлогдсон 1 - 12 дугаар ангийн сурагчид

2023 - 2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВӨЛГӨӨ


№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хамрах хүрээ	Хариуцах зэвс	Хүрэх үр дүн
1	Оноолдох үнэлгээ хийх	9-10 сард	2 - 12 анги	Хичээл зааж буй мэргэжлийн багш нар	Сурлагын хоцрогдолтой сурагчдыг илрүүлэх
2	Дугуйлан өвчлөхд хамрагдалтын судалгаа авах	11 сард	1 - 12 анги	АУБ нар	Сурлагын хоцрогдолтой сурагчдын нийгмийн идэвх орлоогүй байдлыг дүгнэлт хийнэ
3	Хичээлийн судалгаа хийх	11-12 сард	Нийт 55 багш, 1042 сурагч	Сургалтын менежер, ЗАН-ын ахлагч	Сурагчдын сурах үйл ажиллагаанд ажиллалт хийж, 21 дүгээр зууны иргэдийн зөвшилцөл зохи чадваруудыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх арга зүйг туршиж хэрэгжүүлнэ
4	Сурлагын хоцрогдолтой сурагчидтай ганцаарчилсан ярилцлага хийх	12 сард	2-12 ангийн сурагчид	АУБ нар тэмдэглэл хөтөлгөө	Хүүхэд бүрийн сурлагын хоцрогдлын шалтгааныг илрүүлэн түүний мөрсөөр ажиллана
5	Агуулгын хоцрогдол гаргахгүй байх	хичээлийн жилд	1-12 ангийн сурагчид	Мэргэжлийн болон АУБ нар	MEDE.MN цахим платформийг танхимын болон зайны сургалтад өргөн ашиглаж хэвшүүлсээр агуулгын хоцрогдолгүй суралцаана. Мөн бие даан суралцах чадвар
6	Илтгэлийн уралдаан зохион байгуулах	12 сард	5 - 12 ангийн сурагчид	АУБ нар, МХБҮЗ-ын МКБ	Хүүхэд бүрийг өөртөө итгэлтэй, өөрийгөө илэрхийлэх чадвартай болгох дэмжлэг үзүүлнэ
7	“Бирикцэн гэдэс” ангийн ажиллагаа	энэ хичээлийн жилээс эхлэн	2-12 ангийн сурагчид	АУБ нар	Хүүхэд бүр Монгол хүн бүрийн унавалт зохиж нас сэтгэхүйн онцлолт төлбөрсөн 10 өмнөг хичээлийн жилийн туршид ундааг даалгавтай болно.
8	X-READING цахим номын сангаас ном унших	энэ хичээлийн жилээс эхлэн	7 - 12 ангийн сурагчид	АУБ нар, Англи хэлний МКБ	Англи хэлний хичээлийн сургалтын чанарт ахиц гарна
9	Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт хийх	2024 оны 01 сарын эхний 7 хоногт	6-12 ангийн сурагчид	МХБ болон багш бүр	Хүүхэд бүр мэргэжлийн талаар мэдэлтэй болж, илэрхийлэх арга сонгож, зорилготой суралцахад дэмжлэг болно.
10	“Дэм дэмдэгт” ангийн ажиллагаа	хичээлийн жилд	анги бүр	АУБ нар	Сурагчид хөгжлөхдөг болон суралцах үүснэ, давтлага өгөх ажлыг сурагчдын дунд өрнүүлэх замаар бие биенээсээ суралцах дадал хэвшнэ бая болгоно.

БОЛОВСРУУЛСАН СУРГАЛТЫН МЕНЕЖЕР Б.ЛХАВБАДОРЖ

СУРГУУЛЬД СУУРИЛСАН ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭ \2021.10 сар\



СУРГУУЛЬД СУУРИЛСАН ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭ \2023.10 сар\



Нийт сурагчдын 27% нь буюу 281 сурагч сурлагын хоцрогдолтой гэж оношлогдсон. Үүнээс 81 эмэгтэй сурагч буюу 31%, 194 эрэгтэй сурагч буюу 69% эзлэж байна. Энэ үзүүлэлт нь хөвгүүдийн сурлагын чанар хангалтгүй байгааг илтгэж байна.





# “Сурлагын хоцрогдол арилгах” сургуулийн хөтөлбөр, түүний хэрэгжилт

Сурагчдын нийгэмшихүйн болон суралцахуйн чадваруудыг сайжруулахад чиглэсэн дараах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэв.

## ИЛТГЭЛИЙН УРАЛДААН



Илтгэлийг 3 үе шаттай зохион байгуулж, 1-р шатанд 5-12 дугаар ангийн 643 сурагч бүрэн хамрагдаж, 2-р шатанд анги бүрээс 5 эмэгтэй, 5 эрэгтэй сурагч буюу 240 сурагч оролцож, 3-р шатанд 17 сурагч шалгарав.



**Үр дүн:** Сурагчид сумаас болон бусад газраас зохион байгуулсан илтгэлийн уралдаанд бие даан оролцдог болсон.

## УНШИХЫН ГАЙХАМШИГ



Хүүхэд бүрийг номтой нөхөрлүүлэх зорилгоор 2-12 дугаар ангийн сурагч бүр 10 зохиол уншъя аян зарлаж, АУБ нар уншсан номын тэмдэглэл хөтлүүлж ажиллав. Нийт 948 сурагчаас 900 сурагч 2 – 11 хүртэл зохиол уншиж, тэмдэглэл хөтлөв.



Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран “**ХАМТДАА УНШЪЯ**” үйл ажиллагааг зохион байгуулсан.

## ИНДЭРТЭЙ УНШЛАГА

### ИНДЭРТЭЙ УНШЛАГЫН ЯВЦ




Өөртөө итгэлтэй, бусад ойлгомжтой уншиж өгдөг болсон. Уншсаны дараа асуултаар ойлгосон зүйлийг ярилцдаг болсон. Сурагчид асуулт асуухын тулд анхааралтай сонсдог болсон зэрэг сайн талуудтай байв.

### ДҮГНЭЛТ- ҮНЭЛГЭЭ



### 1 минутанд унших үгийн тоо



### ҮР ДҮН:


- Хоцрогдол буурсан
- Унших хурд дээшидлсэн
- Ойлгон унших чадвар сайжирсан
- Номын санд суух дуртай болсон
- Ном хандивлагч гэр бүл олширсон
- Ангийн номын сантай болсон
- Уншсэн номын тэмдэглэл хөтөлбөг болсон





# ЗОРИЛТ–3. Байгууллагын менежментийн төлөвлөлт, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны бүтцийг бий болгож, ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох.

## СУРГУУЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР



## Тэргүүлэх зорилт-1. Хамтын ажиллагааг сажруулах

### ЗОРИЛТ 1-ийн хүрээнд хийх үйл ажиллагааны чиглэл:

- Хичээлийн судалгаа хийх
- Бүлгийн багш нар хамтран ажиллах
- Мэргэжлийн хөгжлийн бүлгээр хамтран ажиллах
- Сайн туршлага тугээн дэлгэрүүлэх, туршлага судлах
- Хүүхдийн хөгжил, төлөвшлийг дэмжсэн үйл ажиллагааг хамтын ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлэх
- Тэгш хамран сургах боломжийн бүрдүүлж ажиллах

## БАГШИЙН МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ



## МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙН БҮЛЭГ

Баян-Уул сумын ЕБС-ийн багшийн "МЭРГЭЖЛИЙН ХӨГЖЛИЙН БҮЛЭГ" 2023-2024 он

№	Судлагдахуунд суурилсан МХБ	МХБ-ийн ахлагч	Багшийн тоо		Суралцахууд суурилсан МХБ	МХБ-ийн ахлагч	Багшийн тоо		
			Мэргэжлийн багш	Бага ангийн багш			Нийт	Багшийн нэр	Нийт
1	Математи-Мэдээлэл зүй	Ө Саруул	7	Ж.Оюунчимэг, Э.Энхжаргал, П.Буяннаргал, Ц.Энхзуул, О.Оюунзуул	12	"Шинэ салхи" МХБ	Э.Нямтөгтох - ТНУ, Б.Жаргалтуяа - Англи хэл, Д.Ганццэг - Биологи, Э.Энхзуул - Англи хэл, Ө.Энхзуул - Физик	6	
2	Байгалийн ухаан	Д.Ганццэг	4	Ц.Цэрэнчимэг, Н.Итгалсуурэн, О.Гантуяа, Д.Батчицаг	8	"Эрдэмт хөвгүүд" МХБ	Б.Дэлгэн - Математик, Б.Батболд - Математик, Б.Хас-Эрдэнэ - Хөгжим, Т.Дашням - Математик	9	
3	Дизайн, технологи	Ш.Цэцэгмаа	3	П.Ононцэцэг, Ж.Гэрэлмаа, Б.Юмжирдулам, Ц.Энхимаа	7	"Уншигчдын гайхалшигч" МХБ	Сургалтын менежер Б.Лхагвадорж	6 - 12 - р ангийн АУБ нар, Сургуулийн номын санч, Сумын номын санч	23
4	Хөгжим	Г.Уянга	2		2	"Online english class"	Англи хэл А.Мөнхтуяа	Б.Жаргалтуяа - Англи хэл, Багш ангийн багш нар	5
5	Монгол хэл, бичиг, уран зохиол	Г.Цэрэндолгор	5	А.Уянга, Б.Оюунтуул, Б.Бурмаа	8	X-reading	Англи хэл Т.Ариунцацэг	Англи хэл - А.Мөнхтуяа, Н.Оюунмаа, Б.Жаргалтуяа, Т.Түвшинцэцэг, Д.Ганчимэг, Э.Энхзуул, АУБ - Б.Пүрэв-Эрдэнэ	8
6	Түүх, нийгмийн ухаан	Л.Нэмдалай	4		4				
7	Гадаад хэл	Н.Оюунмаа	8	Э.Оксана	9				
8	Биеийн тамир	Г.Батсайхан	3		3				
			36	17	53				

Dorjoid Bagsh-Uul Sum EBC -1923-  
 Feldea Gedeso fododedo Yeroehkety  
 Bibesore oa Sorgegoll  
 Fedola

2023-2024 оны хичээлийн "Менежментийн загвар"- аа боловсруулахдаа:

- Тулгамдаж буй асуудал
- Яамны зорилго, зорилт
- Сургуулийн алсын хараа, эрхэм зорилготойгоо уялдуулан талуудын хамтын оролцоонд тулгуурласан.

Багш нарын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор хийх ажлын чиглэлийг хамтын оролцоотойгоор тодорхойлсон.

Байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн багшийн хөгжлийг дэмжих ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэв.

Энэ хичээлийн жилд судлагдахуунд суурилсан 8 МХБ, суралцахууд суурилсан 12 МХБ, нийт 20 МХБ –ийн зохион байгуулалттайгаар:


- Тулгамдаж буй асуудлаа шийдвэрлэх
- Багшийн хөгжлийг дэмжих
- Хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор ажиллалаа.



# Багшийн ажлын гүйцэтгэл, үр дүнд суурилан багш ажлын байрандаа мэргэжлээ дээшлүүлэх, ур чадварт гарсан ахиц, үр дүнг тооцох.

2022 он → 2023 он  
 Ү индекс → ҮI индекс  
 71.28% → 75.87%  
 +4.59

## БАГШИЙН ИНДЕКСИЙН ТҮВШИН



2022 он – Нийт багш нарын 52.6% буюу 30 багш ажлын үр дүнгийн урамшуулал авсан.

2023 он – Нийт багш нарын 67.3% буюу 35 багш ажлын үр дүнгийн урамшуулал авна.

## БАГШИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН (шалгуур тус бүрээр)



№	Багшийн нэр	Шалгуур-1		Шалгуур-2		Шалгуур-3		Шалгуур-4		Нийт		Индекс		БХТ	
		2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023
1	Нямтогтох		79.6		91		98.9		96		88.49		I		1
2	Оюунтунагай	59.2	63.9	82.7	88.6	97.1	97.2	91.4	80.3	76.91	80.27	IV	II	2	1
3	Өнөржаргал	52.4	74.8	81.5	84.6	96.7	89.7	74.8	88	72.65	81.87	IV	II	2	1
4	Пүрэв-Эрдэнэ	46.9	63.1	66.7	93.3	88	94.4	93.2	97.6	65.5	79.18	V	II	3	1
5	Батсайхан	65.5	78.7	77.3	88.9	95.5	85.3	74.8	80.8	77.28	82.82	III	II	2	1
6	Мөнх-Эрдэнэ	60.9	70.9	76.8	77.8	87.4	96.1	93.2	95.6	73.66	83.07	IV	II	2	1
7	Пүрэвсүрэн		62.7		90		99		93.6		80.61	IV	II		1
8	Наранбилэг		69		84.4		88.1		77.2		76.48	V	II	3	1
9	Жаргалмаа	39.8	58.5	61.5	88	100	96	39.4	86.4	62.18	77.03	V	III	3	2
10	Жаргалтуяа	34.9	65.5	79.5	87.3	96.4	94.5	93.2	91.8	71.04	79.86	V	III	3	2
11	Цэрэндолгор	67.5	62.8	50.1	84.8	94.9	92.4	82.8	84.4	73.05	77.16	V	III	3	2
12	Соёлмаа	52.6	55.9	80.6	93.5	97.4	95.7	88.4	83.2	73.44	76.71	IV	III	2	2
13	Ууганбаяр	71.1	69.7	40.5	89.4	63.3	89.9	60	84	72.65	79.6	V	III	3	2
14	Батцэцэг	61.5	58.8	81.7	86.3	93.3	97.5	91.4	96	76.55	77.74	IV	III	2	2
15	Дамдиндорж		63.3		82		92.8		82.2		76.84	V	IV	3	2
16	Хандсүрэн		60.1		82.6		97.4		95.8		77.54	V	IV	3	2
17	Батболд	39.8	52.9	75.7	84.5	88.3	86.5	73	80.4	63.21	70.7	V	IV	3	2
18	Уянга	56.4	61.4	73	90.1	88.2	92.8	98.2	89	71.33	77.96	V	IV	3	2
19	Гэрэлмаа	54.5	62.2	78.8	82.2	95.9	91.7	82.2	71.2	73.13	75.49	V	IV	3	2
20	Оюумаа	54.5	56.7	78.6	87.7	96.1	98.4	93.2	77.4	73.73	77.39	IV	IV	2	2
21	Мөнхбат		70.3		84.1		86.1		81.6		78.37		IV		2
22	Мөнхтуяа	56.8	48.3	79.7	84.7	96.4	88.6	88.4	91.8	74.82	69.86	IV	V	2	3
23	Хас-Эрдэнэ	46.9	50.6	70.6	73.9	85.3	67.9	98.2	77	65.74	61.76	V	V	3	3
24	Мөнгөтуяа		50.2		81.6		91.7		77		70.25	IV	Y	2	3
25	Дөлгөөн		36.3		77.7		86.5		83		61.97	III	Y	2	3
26	Ганчимэг	43.7	53.5	83.8	80.5	97.1	90.7	82.8	83.2	69.65	71.55	V	Y	3	3
27	Ганцэцэг	45.8	47.4	80.4	86.2	96.7	96	82.8	94.4	69.81	72.06	V	Y	3	3
28	Саруул	37.8	45.6	67.7	90.1	91.9	91.9	82.2	78.8	62.23	70.07	V	Y	3	3
29	Бурмаа	58.7	52.1	76.6	83.1	95.1	87.3	67.4	80.8	73.62	70.26	V	Y	3	3
30	Дашням	47.5	32.1	63.6	72.7	91.4	66.8	91.6	79.2	66.07	52.98	V	Y	3	3
31	Түвшинцэцэг	47.7	48.1	78	82.6	95.6	88.4	74.8	60.4	69.48	67.66	V	Y	3	3
32	Оюунцэцэг	52	53.5	77.5	86.6	86.7	92.4	93.2	82.4	69.55	73.22	V	Y	3	3
33	Цэцэгмаа	47.6	60.4	71.5	79.9	92.8	85	88.4	79.2	67.96	72.59	V	Y	3	3
34	Э Энхзул		46.5		89.5		98.6		90		72.88		Y		3
35	Ариунцэцэг		54.7		80.6		96.7		91.4		74.31		IV		2
	Пүнлэж		58.3		84.0		91.0		84.4		74.76				

№	Багшийн нэр	Шалгуур-1		Шалгуур-2		Шалгуур-3		Шалгуур-4		Нийт		Индекс		БХТ	
		2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023	2022	2023
1	Ж.Оюунчимэг	85.4	69.1	76.5	89.8	95.5	89.6	98.2	85	78.3	80.2	III	III	2	2
2	Н.Итгалсүрэн	63.9	63.2	82.7	87	98	95.2	82.2	89.4	78.8	78.9	III	III	2	2
3	О.Оюунзул	93.9	88.1	78.8	92.6	89.6	97.8	93.2	93.2	84.9	92.1	I	I	1	1
4	О.Гантуяа	84.1	74	81	90.3	97.1	92.7	82.8	90.1	83.1	83.1	II	II	1	1
5	Б.Оюунтуул	79	77.5	79.5	92.4	96.7	98	93.2	96	81.2	57.8	II	V	1	3
6	В.Пүрэвбилэг	81.5	75.9	80.4	53.8	97.2	94	78.4	89	85.8	79	I	III	1	2
7	Ц.Энхзул	80.6	86.2	69.1	94.3	81.9	95.1	82.2	84	78.7	90	I	III	1	2
8	Ж.Оюун-Эрдэнэ	71.9	70.4	74.4	88.2	94.7	93.1	82.2	83.4	79.8	80.8	II	II	1	1
9	П.Бунжааргал	68.8	63	87.1	90.7	99	97.8	78.8	92	81.9	79.5	II	III	1	2
10	Б.Бурмаа	67.4	65.3	72.1	91.4	77.9	95.9	60	93.6	71.1	80.2	V	III	3	2
11	Б.Юмжирдулам	68.9	62.5	65.5	89.8	75.1	91.9	60	80	69.6	76.6	V	IV	3	2
12	П.Оюунцэцэг	75	69.9	83.5	91.8	91.3	91.8	91.4	86.4	82.4	80.8	II	II	1	1
13	Ц.Энхмаа	69.5	44.8	80.8	94.3	93.3	93.4	82.2	85	82.7	71.2	II	V	1	3
14	Д.Бачимэг	51.6	75.6	71.2	91.8	93.3	96.5	93.2	90	70.1	80.7	V	II	3	1
15	Б.Баярлам	55.6	53.2	40.8	85.3	83.3	91.5	90.8	80.4	73.3	72.5	IV	V	2	3
16	Ц.Цэрэнчимэг	67.4	67	71.5	94.5	94.3	98.1	78.4	95	76.8	83.3	III	II	2	1
	Дундаж	71.5	65.4	74.7	88.6	91.1	94.5	83	88.3	78.7	79.2				

## МОДУЛЬ СУРГАЛТ

Нийт 60 багш, удирдах ажилтан мэргэжлийн хөгжлийг дэмжих ЗОРИЛТОТ болон СОНГОЛТОТ модуль 110 сургалтад хамрагдаж, 94%-ийн гүйцэтгэлтэй байна.

## ТҮГЭЭН ДЭЛГЭРҮҮЛЭЛТ

Ижил төрлийн сургалтад хамрагдсан багш нар хамтран бусад багш нартаа түгээн дэлгэрүүлэв. Үүнд:

- Хичээлийн судалгааны арга зүй – 10 багш
- Ялгаатай суралцахуйн арга зүй – 6 багш
- Шалгуурт суурилсан даалгавар боловсруулах арга зүй – 4 багш г.м





# Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаанаас ...

## ХИЧЭЭЛИЙН СУДАЛГАА



## САЙН ХИЧЭЭЛ –ҮЙЛ АЖИЛЛАГАА



Халхгол сумын хичээлийн судалгаагаар мэргэшсэн, Япон, БНСУ-д туршлага судалсан багийг урьж, хамтран ажиллаж, туршлага судлаж, МХБ-ээр хичээлийн судалгаа хийж, ээлжит хичээлийн чанарыг сайжруулахад багшийн болон сурагчийн хөгжилд тулгамдаж байгаа асуудлаа тодруулан, хэлэлцэж, засан сайжруулан ажиллаж байна.



- “ХАРИЛЦАН СУРАЛЦАЖ, ХАМТДАА ХӨГЖЬЕ”**
- уриатай нээлттэй хичээл, үйл ажиллагааг жил бүр багш бүрийг хамруулан зохион байгуулдаг. **ҮР ДҮН:**
- Бусдаасаа суралцдаг, туршлагаа түгээн дэлгэрүүлдэг
  - Багшийн ур чадвар, арга зүйд ахиц гарсан
  - Цахим технологийн хэрэглээг нэмэгдүүлсэн
  - Хүүхэд бүрийн оролцоо, өөрийгөө илэрхийлэх чадвар сайжирсан.
  - Ээлжит хичээл бүрийг хүүхдийн хөгжлийг дэмжсэн, хүүхэд төвтэй болгоход чиглүүлдэг.




Дорнодоо Feijme! да Һеуеа feoala  
Vibesore oa Sorgegoll  
Feidea Gedeso fododoo Yeroenkki



# Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан үйл ажиллагаанаас ...


## БАГА АНГИЙН БАГШИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ



Илтгэлийн сэдэв:  
Ээлжит хичээлд хэрэглэгдэхүүнийг  
бүтээгчээр ашиглах нь

Илтгэлч: В.Оюунтун  
Басгийн гишүүн:  
О.Гантуяа  
О.Оюунтун



**СЭДЭВ: “ХАМТЫН ОРОЛЦООНД СУУРИЛСАН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХӨГЖҮҮЛЭХ НЬ”**

Аймгийн засаг даргын санаачилгаар багшийн хөгжлийг дэмжих зорилгоор БШУГ-тай хамтран зохион байгуулсан БАГА АНГИЙН БАГШИЙГ ДЭМЖИХ төслийн уралдаанд бага ангийн 14 багш буюу 90%-ийг хамруулснаар гарсан **үр дүн:**

- 14 багш сайн туршлагаа түгээн дэлгэрүүлсэн
- 1 багш орон сууцны урьдчилгаа 20 сая төгрөгийн урамшуулал авсан.
- Багш нарын хамтын ажиллагаа сайжирсан
- Сургалтын таатай орчин бүрдүүлсэн.
- Эцэг эх, багш, сурагчийн харилцаа, хамтын ажиллагаа сайжирсан

Жил бүр зохион байгуулагддаг эрдэм шинжилгээний хурлын 1 дүгээр шатанд 13 мэргэжлийн бүлгийн 54 багшийг бүрэн хамруулан зохион байгуулж, судалгаа шинжилгээ хийх чадварыг дэмжиж ажилладаг. 1-р шатнаас 4 дүгээр ангийн МХБ-ийн “Индэртэй уншлага” илтгэл шалгарч, бүсэд амжилттай оролцлоо.

**ҮР ДҮН:**

- Багш нарын судалгаа, шинжилгээ хийх чадварт ахиц гарсан.
- Илтгэл бичих чадварт ахиц гарч байна.
- Хамтын ажиллагаа сайжирсан
- Сургалтад тулгамдаж буй асуудлаа илрүүлж, шийдвэрлэх арга замаа тодорхойлон ажиллаж байна.





# Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан СУРГАЛТ

## БАГШИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЧИГЛЭЛЭЭР ЗОХИОН БАЙГУУЛСАН СУРГАЛТ:

- “Боловсролын салбарын эрх зүйн шинэчлэлт” түгээн дэлгэрүүлэх сургалт – Сургуулийн захирал Б.Батхуяг
- “Боловсролын үнэлгээ” багшийн хөгжлийг дэмжих сургалт – Үнэлгээ хариуцсан менежер Л.Гантулга
- “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт” багшийн хөгжлийг дэмжих сургалт – Багшийн хөгжил хариуцсан менежер Б.Лхагвадорж
- “Сургуулийн менежмент” түгээн дэлгэрүүлэх сургалт - Багшийн хөгжил хариуцсан менежер Б.Лхагвадорж
- “Блюпринт ба блүмийн таксоном” залуу багш нарт зориулсан сургалт – Бага боловсролын менежер Б.Энхжаргал





**ЗОРИЛТ–4. “Тэргүүлэх болон Зөвлөх багшийн манлайлал” –ыг дээшлүүлэх арга хэмжээ, ахмад багшийн зөвлөх үйлчилгээ, багш, ажилтны солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх.**

### ТЭРГҮҮЛЭХ ЗЭРЭГТЭЙ БАГШИЙН МАНЛАЙЛАЛ

- Халхгол сумын “Хичээлийн судалгааны баг” - ийн хамтарсан үйл ажиллагааны хүрээнд багш **Ц.Цэрэнчимэг** 5-р ангид туршилтат хичээл зааж, хэлэлцүүлэв.
- Сургалтын менежер **Б.Энхжаргал** залуу багш нарт **Хичээл гэж юу вэ?, Блюпринт ба Блүмийн таксоном гэж юу болох** тухай сургалтуудыг хийж 4 залуу багш тус бүрт нэг нэг **үзүүлэх хичээл** зааж, туршлагаа түгээв.
- Багш **П.Буянжаргал** сурагчдын уншлагыг дэмжиж **“Сагстай ном”** аялуулах ажлыг зохион байгуулж ажиллав. Үүнд 19 бүлгийн 504 сурагчдад 196 номыг аялуулан номын тэмдэглэл хөтлөлтөөр бүтээлийн үзэсгэлэн гаргав.

### АХМАД БАГШИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

- Ахмад багш **В.Пүрэвжил** залуу багш нарт үсэг таниулах үзүүлэх хичээл 2 удаа хийв.
- Ахмад багш **Л.Амарзаяа, В.Пүрэвжил** нарыг бага ангийн багшийг дэмжих төслийн II шатны **“Хичээл заах”** 1-р даалгаврын зочин шүүгчээр,
- Ахмад багш **Л.Амарзаяа** БАБД төслийн II шатны **“Эцэг эх, асран хамгаалагчтай ажиласан байдал”** 2-р даалгаврын зочин шүүгчээр,
- Ахмад багш **Д.Оюунчимэг** БАБД төслийн **“Анги удирдах ажил”** 3-р даалгаврын зочин шүүгчээр тус тус ажиллаж, зөвлөн туслаж, хамтран ажиллав.





**ЗОРИЛТ–5.** Багш, ажилтан, албан хаагчдад стрессээс сэргийлэх , сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг үе шаттай зохион байгуулах.

**Энэ хичээлийн жилд БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ ТӨЛӨВШҮҮЛЭХ тэргүүлэх зорилт тавин ажилласан.**



**Кофе юу?**



**Цай юу?**

Бага ангийн 19 багш, сургалтын менежер нар энэхүү үйл ажиллагааг хамтран зохион байгуулж, ажил хэрэгч, дотно яриа өрнүүлж, хамт олны дотоод эерэг уур амьсгал бүрдүүллээ.

### **БАГШ БУС АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТ**



**Сэдэв: БАЙГУУЛЛАГЫН СОЁЛ**  
Боловсролын байгууллагын ажилтны ажлын онцлог, байгууллагын алсын хараа, үнэт зүйл, соёлын талаар санал солилцож, мэдээлэл өгөв.

**Байгууллагын соёлд гарсан эерэг үр дүн:**

- Мэндлэх соёлыг маш сайн хэвшүүлсэн
- Багийн хамтын ажиллагаа сайжирсан.
- Мэргэжлийн бүлэг, заах аргын нэгдлүүд сургуулийн логотой хувцсаар жигдэрсэн
- Лхагва гараг бүр байгууллагын багш, ажилчдын хурал хийж хэвшсэн.
- Багш, ажилтан бүр хариуцсан ажилдаа эзэн байж чаддаг.









**ЗОРИЛТ–6. Сургуулийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, аливаа гадуурхал, дарамт, үе тэнгийнхний дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх, мэдээлэл хүлээн авах, хүүхэд хамгааллын багийн үйл ажиллагааг сайжруулж, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурах, хөгжих, төлөвших үйл явцыг дэмжих тусгайлсан арга хэмжээг багш, ажилтан, эцэг эх, асран хамгаалагч, олон нийтийн оролцоо, түншлэлд тулгуурлан хэрэгжүүлж, үр дүнг тооцох.**

## ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН БАГ


Дорнод аймгийн Баян-Уул сумын 2024.05.03-ны Уяачдын холбооноос зохион байгуулж байгаа уралдаанд оролцож буй Унаач хүүхдүүдэд зөвлөмж хүргэж ажиллаа.



You, M. Алгирмаа and 14 others 9 shares

Сургуулийн хүүхэд хамгааллын багийн зүгээс Баян-Уул сумын Онон улз уяачдын холбоонд 05.10-ны өдөр зохион байгуулагдах бүсийн хурдан морины уралдаанд хүүхдийн аюулгүй байдал, эрүүл мэндэд онцгой анхаарч ажиллах тоот бичгийг уяачдын холбоон хүргэж мөн 2-6 дугаар ангийн **нийт-23 уралдаанч сурагчдад 150 ширхэг брошур зөвлөмжийг** хүргэж ажиллав.

Бага ангийн сурагчид сургуулийн ойр орчмын дэлгүүрээс **хориотой хүнсний бүтээгдэхүүн** худалдан авч байгаатай холбоотойгоор сургуулийн Хүүхэд хамгааллын багаас **санамж хуудас гаргаж сумын хэмжээнд нийт 22-19 дэлгүүрт хүргүүлж**, сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтэнд уламжлснаар дорнод аймгийн Улсын байцаагч ирж сумын ажлын хэсэгтэй хамтран үр дүнтэй ажилласан.



## ДЭЭРЭЛХЭЛТ ДЭЛГЭРЭХ ЁСГҮЙ АЯН



Аяны хүрээнд цахим болон сургуулийн орчинд байршуулах, сургалт хийх, сурагчдын зөвлөлөөс контент хийж, байршуулах, санал хүсэлтийн хайрцагаар мэдээлэл авах зэрэг олон хэлбэрээр ажилласан.

## ЭЦЭГ ЭХ ЗОХИЦУУЛАГЧ



Сургуулийн нийт 39 бүлгийн эцэг эх, асран хамгаалагч нар “Эцэг эх зохицуулагч” нэгдсэн арга хэмжээнд өглөө 07<sup>40</sup>-08<sup>10</sup>, өдөр 12<sup>40</sup>-13<sup>10</sup>, оройн 17<sup>40</sup> – 18<sup>10</sup> цагийн хооронд тогтмол оролцож, хамтран ажилласан.



## ЗОРИЛТ–7. Байгууллагын орчны эрсдлийг бууруулах, дотоод хяналтыг тогтворжуулан, тусгайлсан арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг тооцох



2а ангийн эцэг эхчүүд сургуулийн гадна орчны эрсдлийн үнэлгээ хийж, гадна хаалганы хашлагыг шинэчилсэн.



Өмнө нь



Одоо

Эцэг эхийн санаачилан эхлүүлсэн ажлыг сургуулийн ажилтнууд өргөжүүлэн тэмдэг, тэмдэглэгээ хийж, аюулгүй байдлыг сайжруулсан.

### Байгууллагын орчны эрсдлийг бууруулах чиглэлээр хийсэн ажлуудаас...

- Орчны аюулгүй байдлын эрсдлийн өөрийн үнэлгээ хийж, түүний мөрөөр ажиллаж байна
- Сургуулийн орчинд замын тэмдэг, тэмдэглэгээ хийж, машины зогсоолыг шинэчлэн хязгаарлалт хийсэн.
- Дотуур байрны гадна орчны гэрэлтүүлгийг сольсон
- Сурагчдын ширээ сандлыг шинэчилсэн нь хүүхэд гэмтэх, хувцас хунараа урах эрсдлээс сэргийлсэн.





## ЗОРИЛТ–8. Шинэлэг, онцлог, бусдад туршлага болохуйц үйл ажиллагаа, арга хэмжээ.

### ИЛТГЭЛИЙН УРАЛДААН

Сурагчдын эмх цэгцтэй ярих, илтгэх чадварыг сайжруулах зорилгоор илтгэлийн уралдааныг 3 үе шаттайгаар зохион байгуулсан. Энэ хичээлийн жилд 5-12 дугаар ангийн 640 гаруй сурагчдыг бүрэн хамруулсан ба цаашид 2 -12 дугаар ангийн сурагчдын дунд жил бүр зохион байгуулж ажиллана.

Үр дүн:

- Бусдын өмнө гарч ярих чадварт суралцсан
- Эрэл хайгуул хийж, уншиж, судалдаг болсон
- Илтгэх зүйлээ найруулан бичих, эмх цэгцтэй ярих чадвар сайжирсан
- Өөртөө итгэх итгэл нэмэгдсэн

### УНШИХЫН ГАЙХАМШИГ

Хүүхэд бүрийг номтой нөхөрлүүлэх чиглэлээр олон бүтээлч ажил хийсэн. Үүнд:

- **Уншихын гайхамшиг аян** – 2-12 дугаар ангийн хүүхэд бүр жил бүр заавал унших 10 зохиолыг тодорхойлж, 948 хүүхэд уншихаас 900 сурагч 2 -11 зохиол уншиж, энэ хичээлийн жилд 53%-ийн гүйцэтгэлтэй байна.
- **Индэртэй уншлага** – 2-5 анги. Илтгэл бичиж туршлагаа түгээсэн
- **“Хамтдаа уншъя” аян** – эцэг эх, асран хамгаалагчтай хамт
- **“Сагстай ном”** аялуулсан
- **Ангийн номын сантай** болсон.
- **Дотуур байрны тасаг бүр номын сантай** болсон.

### ЭРДЭМТ ХӨВГҮҮД

Сурлагын хоцрогдолтой сурагчдын 68% нь эрэгтэй сурагч, мөн ЭЕШ-д эрэгтэй сурагчдын амжилт буурсан зэрэг шалтгаанаар энэ хичээлийн жилд **“Эрдэм хөвгүүд” эрэгтэй багш нарын мэргэжлийн бүлэг** ажилласан. Энэ ажлын хүрээнд:

- Оношлох үнэлгээний үр дүнд анализ хийсэн
- Аливаа зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд хүйсийн харилцааг тэнцвэртэй оролцуулсан
- Оны тэргүүний Номч хүү шалгаруулсан



**ХАРИЛЦАН СУРАЛЦАЖ,  
ХАМТДАА ХӨГЖЬЕ.  
БАЯРЛАЛАА**

**Feldea Gedeso fodoedo Yeroenkhei**

**VibEsore oa Sorgegöll**

**Doronedo Feimef oa hEvea fexola**